

German - Mongolian Technical cooperation

BGR - MMHI Project "Advisory Services for Sustainable Mineral Resources Management"

PN: 2020.2036.0

### **Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх санал авах тухай**

Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яам, АМГТГ ба УГА нь ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-тэй хамтран “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд

### **“ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ АЖЛЫГ ЧИГЛҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ТОГТОЛЦОOG БОЛОВСРУУЛАХ”**

ажлыг гүйцэтгүүлэх гэрээг байгуулахаар бэлтгэж байна.

#### **Ажлын товч тодорхойлолт:**

Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд эрдэс баялгийн салбар нь Монгол улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллөөр голлох салбар болон хөгжсөн төдийгүй тус салбарын өсөлт бууралт нь манай улсыг эдийн засгийн өсөлт, бууралтыг тодорхойлдог болсон байна. Тус салбарын улсын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг татвар, гааль зэрэг төрийн байгууллагын мэдээллийн санд сууринлан тодорхойлж байгаа боловч үзүүлж буй нөлөөллийг нарийвчлалтайгаар бүрэн гүйцэт тодорхойлох нь бэрхшээлтэй байна. Иймд системтэй үнэлгээ хийх тодорхой, бүтэцтэй тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Нөлөөллийн үнэлгээ нь уул уурхайн үйл ажиллагааны улс, орон нутаг, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх олон талт нөлөөллийн талаар үнэ цэнэтэй ойлголт өгөх болно. Энэхүү ойлголт нь шийдвэр гаргах үйл явцад мэдээлэл өгч, уул уурхайн тогтвортой үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулахад чиглэнэ.

Энэхүү ажлын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.10-д заасан Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээг чиглүүлэх арга зүйн тогтолцоог боловсруулах явдал юм.

**Төслийн мэдээлэл:** Монгол Улсын геологи, уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг чиглүүлэх арга зүйн тогтолцоог боловсруулах.

**Гэрээ байгуулах төрөл:** хязгаарлагдмал сонгон шалгаруулалт, уригдсан ААН, мэргэжилтнүүдийн хүрээнд  
**Санал хүлээн авах эцсийн хугацаа:** 2024-07-...

**Зөвлөхийн профайл:** Уул уурхай, геологи, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал, нийгэм эдийн засгийн үнэлгээний чиглэлээр арвин туршлагатай Монголын болон олон улсын шинжээч, компани/ТББ; англи, монгол хэлний өндөр мэдлэгтэй байх шаардлагатай

**Төлөв:** Богино жагсаалтад багтсан сонирхсон компаниуд болон мэргэжилтнүүдийг дээр дурдсан эцсийн хугацаанаас өмнө саналаа ирүүлэхийг урьж байна.

**Холбоо барих хүн:** Хайме Фернандез

**Имэйл хаяг:** [jaime.fernandez@bgr.de](mailto:jaime.fernandez@bgr.de)

**Монгол улс, Улаанбаатар, Нэгдсэн Үндэстний гудамж-5/2,**

**Засгийн газрын II байр, 118 тоот**

## АЖЛЫН ДААЛГАВАР

Уул уурхайн, хүнд үйлдвэрийн яам, АМГТГ ба УГА нь ХБНГУ-ын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн (БГР)-тэй хамтран “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд

### “ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ АЖЛЫГ ЧИГЛҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРУУЛАХ”

ажлыг гүйцэтгүүлэх гэрээг байгуулахаар бэлтгэж байна.

#### БҮЛЭГ 1: ТАНИЛЦУУЛГА

Герман-Монголын хамтын ажиллагааны “Эрдэс баялгийн тогтвортой менежментийн зөвлөх үйлчилгээ” төсөл нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг хариуцлагатай, ил тод, тогтвортой уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, зохицуулалтын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг. Энэ нь тоон өгөгдлийн менежмент, арга, аргачлалыг хөгжүүлэх, мэргэжлийн чадавхийг дэмжих гэсэн гурван үндсэн чиглэлд анхаарлаа хандуулдаг. Энэхүү ажлын даалгавар нь 2-р ажлын талбар болох Монголын геологи, уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг (НЭЗҮ) үнэлэх аргачлалыг бий болгоход чиглэгдсэн болно.

Сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд эрдэс баялгийн салбар нь Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөллөөр голлох салбар болон хөгжсөн төдийгүй тус салбарын өсөлт бууралт нь улсын эдийн засгийн өсөлт, бууралтыг тодорхойлдог болсон байна. Тодруулбал, эрдэс баялгийн салбар нь улсын төсвийн орлогын 32%, аж үйлдвэрийн салбарын 79.8%, нийт экспортын орлогын 89%, дотоодын нийт бүтээгдэхүүний 24%, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73% (Сүүлийн 12 жилийн дунджаар)-ийг бүрдүүлэхээс гадна Монгол Улсын валютын нөөцийг нэмэгдүүлж буй голлох салбар болоод байна.

Тус салбарын улсын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг татвар, гааль зэрэг төрийн байгууллагын мэдээллийн санд суурilan тодорхойлж байгаа боловч үзүүлж буй нөлөөллийг нарийвчлалтайгаар бүрэн гүйцэт тодорхойлох нь бэрхшээлтэй байна. Иймд системтэй үнэлгээ хийх тодорхой, бүтэцтэй тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Нөлөөллийн үнэлгээ нь уул уурхайн үйл ажиллагааны улс, орон нутаг, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх олон талт нөлөөллийн талаар үнэ цэнэтэй ойлголт өгөх болно. Энэхүү ойлголт нь шийдвэр гаргах үйл явцад мэдээлэл өгч, уул уурхайн тогтвортой үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулахад чиглэнэ.

Иймд УУХҮЯ болон АМГТГ санаачилан Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.10 дахь заалт буюу “Уул уурхайн үйлдвэрлэлээс улс орны эдийн засаг, нийгэмд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх, дүгнэлт гаргах”-ын хүрээнд салбарын нийгэм, эдийн засгийн үнэлгээний аргачлал боловсруулах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд “Эрдэс баялгийн тогтвортой менежментийн зөвлөх үйлчилгээ” төсөл 2022 оны 8-р сард “Монгол улсын уул уурхайн салбарын нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ сэдэвт” хурлыг зохион байгуулсан ба холбогдох төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, их сургуулиуд болон олон улсын байгууллагууд оролцож санал бодлоо солилцсоны үр дүнд дараах дүгнэлт, зөвлөмжүүдийг гаргасан. Үүнд:

**Дүгнэлт:**

- Салбарын хэмжээнд нэгдсэн аргачлалаар НЭЗҮ хийх нь уул уурхайн салбараас нийгэм ба эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг стандарт байдлаар тодорхойлох, олон нийтэд мэдээллийг хүргэхэд илүү хялбар болох гэх мэт олон давуу тал үүсгэнэ.
- Өнөөгийн байдлаар НЭЗҮ нь зөвхөн төслийн хэмжээнд хийгдэж байгаа бөгөөд энэхүү аргачлал нь салбарын хэмжээнд үнэлгээ хийхэд шаардлага хангахгүй байна.
- Үнэлгээг тодорхой хугацааны давтамжтайгаар, улсын болон бүсийн хэмжээнд талуудын оролцоотойгоор нэгдмэл аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу хийдэг байх нь зүйтэй.

**Зөвлөмж:**

- Төрийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдыг оролцуулсан олон талт Ажлын хэсгийг байгуулах. УУХҮЯ, холбогдох байгууллагуудын төлөөлүүдийг оролцуулсан үнэлгээний аргачлал боловсруулахад дэмжлэг үзүүлэх, тухайн асуудлаар тэдгээрийн уялдаа, холбоог хангах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулах.
- Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн үнэлгээний аргачлал боловсруулах ажлыг зохион байгуулах, талуудын оролцоог ханганд хэлэлцүүлэх ба батлуулах арга хэмжээг авах.

Зөвлөмжийн дагуу олон талт ажлын хэсгийг 2023 онд байгуулсан ба тус ажлын хэсэгт холбогдох төрийн байгууллагууд, ТББ ба БГР-ийн төслөөс гишүүд томилогдон ажиллаж байна.

**БҮЛЭГ 2: ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

№	Агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1.	Зөвлөх үйлчилгээний нэр	“Геологи, уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг үнэлэх ажлыг чиглүүлэх арга зүйн тогтолцоог боловсруулах”
2.	Захиалагч	Герман-Монголын хамтын ажиллагааны “Эрдэс баялгийн тогтвортой менежментийн зөвлөх үйлчилгээ” төсөл (Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам ба ХБНГУ-ын “Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн” хамтран хэрэгжүүлж буй)
3.	Зөвлөх үйлчилгээний төрөл	хязгаарлагдмал сонгон шалгаруулалт, уригдсан ААН, мэргэжилтнүүдийн хүрээнд
4.	Санал хүлээн авах хугацаа	2024-07-29
5.	Санал ирүүлэх хаяг	И-мэйл хаяг: <a href="mailto:jaimे.fernandez@bgr.de">jaimе.fernandez@bgr.de</a> “Эрдэс баялгийн тогтвортой менежментийн зөвлөх үйлчилгээ” төсөл Ажлын байрны хаяг: ЗГ-ын 2-р байр, НҮБ-ийн гудамж 5/2, 118 тоот
6.	Саналын хүчинтэй байх хугацаа	Санал нь ирүүлсэн өдрөөс 60 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7.	Зөвлөх үйлчилгээний үнэ ба холбогдох татвар	Зөвлөх үйлчилгээний үнийн саналд хязгаар тавихгүй бөгөөд бага үнийн дүн давуу байдал олгоно. Гэрээний төлбөрийг бүхэлд нь нэг удаа эсвэл гэрээнд заасны дагуу хэсэгчилэн төлөх бөгөөд бичиг хэрэг, тээврийн зардлыг нэмж төлөхгүй. БГР төсөл нь НӨАТ-аас чөлөөлөгддөг.
8.	Саналыг шалгаруулах аргачлал	Саналыг боловсруулалтын чанар, баг бүрэлдэхүүний ажлын туршлага болон үнэ гэсэн шалгуур үзүүлэлтээр шалгаруулна. Хэрэв талууд гэрээний нөхцөлийг харилцан тохиролцож чадахгүй бол 2 дугаар байранд орсон санал ирүүлсэн зөвлөхтэй гэрээ байгуулах ажлыг эхлүүлнэ.

9.	<b>Саналд үнэлгээ өгөх бүтэц</b>	Техникийн үнэлгээ 50%, үнийн санал 50%-ийн оноог тус тус авна. Дэлгэрэнгүйг ажлын даалгаврын 4.7 ба 4.8 дах хэсгээс харна уу.
10.	<b>Захиалагчийн үүрэг, хариуцлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Шаардлагатай мэдээлэл, өгөгдлүүдийг гарган өгөх.</li> <li>- Ажлын даалгавартай холбоотой аливаа асуудлыг тодруулах, зөвлөх болон хэлэлцэх ажлыг цаг тухай бүрт нь шуурхай хэрэгжүүлнэ.</li> <li>- Гүйцэтгэсэн ажлын явцыг хянах, тайлан судалгаатай танилцах, санал зөвлөмж өгөх ажлыг тогтмол гүйцэтгэх шаардлагатай ажилтнуудаар хангах.</li> <li>- Зөвлөхөд логистикийн туслалцаа үзүүлэх (гол оролцогч талууд болон агентлагуудын холбоо барих хаягийг бэлэн болгох, шаардлагатай мэдээллийг олж авахын тулд холбогдох байгууллагуудад танилцуулга захидал илгээх).</li> <li>- Шаардлагатай хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</li> <li>- Оролцогч талуудтай хурал, хэлэлцүүлэг зохион байгуулахад хурлын ерөө болон бусад зүйлсээр хангах.</li> </ul>
11.	<b>Зөвлөх үйлчилгээний зорилго</b>	“Уул уурхайн салбарын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлж, олон улсын шилдэг туршлага, түүнийг хэрэгжүүлэх, Монгол Улсын хяналт тавих чадавхи болон холбогдох мэдээллийг харгалzan үзсэн” нөлөөллийн үнэлгээний арга зүйн тогтолцоо боловсруулах ажлын санал хүлээн авах.
12.	<b>Зөвлөх үйлчилгээний үр дүн</b>	“Геологи, уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг үнэлэх ажлыг чиглүүлэх арга зүйн тогтолцоо”-ны төсөл
13.	<b>Зөвлөх үйлчилгээний хүрээнд заавал хийгдэх ажил (үүгээр хязгаарлагдахгүй)</b>	Бүлэг 4-т заасан ажлын даалгаврыг харах.
14.	<b>Санал боловсруулах</b>	Саналыг Монгол ба Англи хэл дээр боловсруулж, гарын үсэн зурж баталгаажуулсан байх ба PDF форматаар ирүүлнэ. Үнийн саналыг төгрөгөөр тооцсон байна. Саналыг санал хүлээн авахаар заагдсан имэйлд заасан хугацаа дуусахаас өмнө ирүүлнэ.
15.	<b>Судалгааны тайлангийн үе шат</b>	Бүлэг 4.5-т заасан ажлын даалгаврыг харах.

### БҮЛЭГ 3: САНАЛЫН НӨХЦӨЛ

#### 3.1. Ерөнхий зүйл

- Санал боловсруулахтай холбоотой гарах зардлыг санал боловсруулагч бүрэн хариуцна.
- Үйлчлүүлэгч нь зөвлөхүүдийн өмнө хариуцлага хүлээхгүйгээр гэрээ байгуулахаас өмнө хүссэн үедээ сонгон шалгаруулалтыг цуцлах эрхтэй.
- Зөвлөхүүд зөвхөн нэг санал гаргаж болно. Хэрэв зөвлөх, эсвэл санал болгож буй зөвлөх ажилтан гишүүн нэгээс олон саналд оролцсон бол уг саналыг хасна.
- Саналын хамгийн бага хүчинтэй хугацааг мэдээллийн хуудсанд заасан болно. Энэ хугацаанд зөвлөхүүд саналд дэвшүүлсэн мэргэжлийн боловсон хүчний бэлэн байдлыг хангана.
- Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамгаар баталгаажсан байх.

### 3.2. Хэл

- Санал болгож буй зөвлөхийн ажилтнууд Монгол хэлний бичгийн өндөр чадвартай, Англи хэлний ахисан түвшиний мэдлэгтэй байх нь чухал давуу тал болно.
- Саналыг Монгол, Англи хэл дээр боловсруулсан байна.
- Захиалагчтай харилцах албан ёсны хэл нь Монгол, Англи байна.

### 3.3. Саналын бүтцэд тавигдах шаардлагууд

- Санал нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
  - Байгууллагын товч танилцуулга (1 хуудас)
  - Багийн гишүүдийн танилцуулга ба төсөлд хариуцах ажил
  - Ижил тестэй судалгааны ажил гүйцэтгэсэн тухай мэдээлэл
  - Ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөө – ажиллах хүн цаг ба зардлын задаргаа
- Санхүүгийн тооцоолол
  - Зөвлөх үйлчилгээний нийт үнийн дүн
  - Бусад гарах зардлын нийт дүн (бичиг хэрэг, хэвлэх, тээвэр гэх мэт)
  - Холбогдох татварууд
  - НӨАТ оруулаагүй нийт саналын үнийн дүн

## БҮЛЭГ 4. АЖЛЫН ДААЛГАВАР

**Ажлын нэр:** “Геологи, уул үүрхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг үнэлэх ба дүгнэх ажлыг чиглүүлэх аргачлалын бүрэн ажлын багц боловсруулах”

**Гэрээний хугацаа:**

8 сар

**Эхлэх:**

08/2024

**Дуусах:**

02/2025

**Төсөл:** Герман-Монголын хамтын ажиллагааны “Эрдэс баялгийн тогтвортой менежментийн зөвлөх үйлчилгээ” төсөл

**Бараа/үйлчилгээний захиалагч:** УУХҮЯ, АМГТГ ба БГР төсөл

**Ажиллах газар:** УУХҮЯ-ны ажилтнуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай тул баг эсвэл багийн гишүүд нь Улаанбаатарт байх хэрэгтэй.

**Төлбөрийн хуваарь:** УУХҮЯ ба БГР-ийн хүлээн зөвшөөрсөн тайлан, ажлын гүйцэтгэлийн дагуу төлбөрийг 4 хуваана.

### 4.1. Удиртгал

Геологи, уул үүрхайн нийгэм, эдийн засгийн үр нөлөөг үнэлэх нь ашигт малтмалын нөөцийн тогтвортой менежментийг төлөвшүүлэх, нөөцийн бодлого төлөвлөлтийг боловсруулахад чухал ач холбогдолтой юм. Иж бүрэн үнэлгээ хийхэд тоон болон чанарын үзүүлэлтүүдийг нэгтгэсэн системчилсэн хандлага зайлшгүй шаардлагатай. Гэвч нөлөөллийн үнэлгээний үндэсний стандарт аргачлал одоогоор дутмаг байна.

2014 онд АМТХ-д нэмэлтээр орсон 11.1.10 дахь зүйл нь уул үүрхайн үйл ажиллагааны нийгэм, эдийн засгийн үр нөлөөг тогтмол үнэлж байх шаардлагатайг тогтоож, хариуцлагатай уул үүрхайн үйл ажиллагааг хангах амин чухал хэрэгсэл болохыг онцолсон гэж үзэж байна.

Иймд системтэйгээр үнэлгээ хийх тодорхой, бүтэц бүхий тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Ийм үнэлгээ нь уул үүрхайн үйл ажиллагаа нь орон нутаг, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх

олон талт нөлөөллийн талаар үнэ цэнэтэй ойлголт өгөх болно. Энэхүү ойлголт нь шийдвэр гаргах үйл явцад мэдээлэл өгч, уул уурхайн тогтвортой үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулахад чиглэнэ.

#### 4.2. Зорилго

Ерөнхий зорилго: “Уул уурхайн салбарын нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлж, дүгнэх” болон түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих олон улсын шилдэг туршлага, Монгол Улсын чадавхи, одоо байгаа мэдээллийг харгалzan үзсэн НЭЗҮ-ний аргачлалын нэгдсэн ажлын багц боловсруулах санал хүлээн авах. Онцгой зорилтууд:

Зорилт 1. Монгол Улсын НЭЗҮ аргачлал боловсруулахад хувь нэмрээ оруулах элементүүдийг тодорхойлохын тулд холбогдох улс орнуудын эрдэс баялгийн салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг үнэлэх, дүгнэх аргачлалд дүн шинжилгэх хийх.

Зорилт 2. Монгол Улсын уул уурхайн салбартай холбоотой төрийн бодлогод (жишээлбэл: байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, хөгжил, эдийн засаг гэх мэт) хамаарах мэдээлэл, мониторингийн системд дүн шинжилгэх хийж, одоо байгаа хүчин чадал, түүнчлэн уул уурхайн салбарын нөлөөллийг үнэлэхэд хэрэгтэй мэдээллийг тодорхойлох.

Зорилт 3. Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийхэд чиглүүлэх НЭЗҮ-ний аргачлалыг боловсруулах ба мөн үнэлгээг гүйцэтгэхэд хэрэглэгдэх одоо байгаа шалгуур үзүүлэлтүүдийг багтаасан, эсвэл байгаа мэдээлэлд үндэслэн шинэ шалгуур үзүүлэлтүүдийг санал болгох.

#### 4.3. Ажлын хүрээ, тодорхойлолт

Зөвлөх нь дээр дурдсан зорилгод хүрэхийн тулд бие даасан шинжээчдийн хувьд дараах даалгавруудыг гүйцэтгэнэ.

1. Монгол Улсын чадавхи, одоо байгаа мэдээлэл, олон улсын шилдэг туршлагад үндэслэн Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг хийхэд чиглүүлэх НЭЗҮ-ний аргачлалыг санал болгох.
2. Төслийн зорилтыг үр дүнтэй, цаг тухайд нь биелүүлэхийн тулд УУХҮЯ-ны ажилтнуудтай нягт харилцаатай байж, ажлын явцыг хянах, тэдний санал хүсэлтийг хүлээн авах.
3. Гэрээт ажлын үйл ажиллагаанд шаардагдах дүн шинжилгээ хийх санал болгож буй арга зүйг нөхөх ба/эсвэл дэлгэрэнгүй болгох.
4. Энэхүү ажлын даалгаврын дагуу ажлыг гүйцэтгэхээр зохион байгуулагдсан бүх биечлэн болон алсын зайн ажлын уулзалтад оролцох.
5. Энэхүү ажлын даалгаварт заасан үйл ажиллагааны хугацааг баримтлах.
6. Тайлан хүргүүлсэний дагуу ирсэн УУХҮЯ болон БГР төслийн санал хүсэлтэд цаг тухайд нь хариулах, мөн тайланг баталгаажуулах хүсэлт гаргах.
7. Энэхүү ажлын даалгаврын дагуу тогтоосон хугацаанд ажлын үр дүнг хүргэх.

#### 4.4. Үйл ажиллагааны тодорхойлолт

Тавигдсан зорилгodoо хүрэхийн тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

#	Үйл ажиллагаа	Хүлээгдэж буй бүтээгдэхүүн
1	1. Даалгаврыг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг УУХҮЯ, БГР төсөлтэй тохиролцон боловсруулах	Эхлэх уулзалтын үеэр ирсэн санал хүсэлтийг тусгасан ажлын нарийвчилсан төлөвлөгөө.
2	2. Канад, АНУ, түүнчлэн зөвлөх багийн тодорхойлсон бусад улс, олон улсын байгууллагуудад хэрэгжиж буй Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн дүгнэлт, үнэлгээний аргачлалд	Тайлан: Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, үнэлгээний аргачлалын олон улсын туршлага' Энэ тайланда:

	<p>дүн шинжилгээ хийх,. Энэхүү шинжилгээнд тусгайлан ном зохиол (жишээлбэл, засгийн газрын тайлан, судалгаа, шинжлэх ухааны нийтлэл) болон хянан үзэж буй НЭЭҮ аргачлалыг хариуцдаг төрийн байгууллага, олон улсын байгууллагуудын вэб сайтад дүн шинжилгээ хийх (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй байж болно). Мөн судалгаанд хамрагдаж буй аргачлалтай хамаарлтай хариуцах хүмүүс болон бусад холбогдох талуудтай цахим шуудан, утсаар болон/эсвэл видео хурлаар ярилцлага, зөвлөлдөх зэрэг орно. Ярилцлага, зөвлөгөөнийг УУХҮЯ, БГР төсөлтэй урьдчилан тохиролцоно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>Системд дүн шинжилгээ хийхэд ашигласан арга зүйн тодорхойлолт.</li> <li>Системийн компакт дүн шинжилгээ хийхдээ дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.             <ul style="list-style-type: none"> <li>хянацсан шалгуур үзүүлэлтүүдийн системийн ялгаа ба ижил төстэй байдал;</li> <li>УУХҮЯ-ийн бүрэн эрх, чадавхийн үүднээс авч үзсэн системийн давуу болон сүл талууд; болон</li> <li>Ур амьсгалын өөрчлөлтийн үндэсний бодлогын шалгуур үзүүлэлтийн системийг боловсруулах, ажиллуулахад анхаарах зүйлс.</li> </ul> </li> <li>Бүрэн дүрсэлсэн хуудаснууд (тайлангийн хавсралт болгон оруулсан болно).</li> </ul>
3	<p>3. Монгол Улсад хэрэгжиж буй үүл уурхайн салбарт (жишээлбэл: байгаль орчин, үүр амьсгалын өөрчлөлт, хөгжил, эдийн засаг, нийгмийн гэх мэт) холбогдох төрийн бодлогын мэдээлэл, хяналтын тогтолцоонд дүн шинжилгээ хийх.</p> <p>Шинжилгээнд хамрагдах мэдээллийн эх сурвалжуудад дараах зүйлсийг багтаана:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 1212.mn</li> <li>• eMongolia</li> <li>• УУКС</li> <li>• ГМИС</li> <li>• ОҮИТБС</li> <li>• Татвар</li> <li>• БОАЖА</li> <li>• Хөдөлмөр, нийгмийн хамгааллын байгууллагууд</li> <li>• ... гэх мэт.</li> </ul> <p>Эдгээр мэдээллийн эх сурвалжуудыг судлах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа нь дараах ажиллагааг багтаах ба мөн үүгээр хязгаарлагдахгүй. Тухайлбал: боломжит онлайн сувгуудыг ашиглах, тусгай ном зохиол (жишээлбэл, засгийн газрын тайлан, судалгаа, шинжлэх ухааны нийтлэл) судлах, эдгээр системийг ажиллуулдаг байгууллага, байгууллагуудын вэбсайтыг шалгах зэрэг орно. Мөн судалгаанд хамрагдаж буй аргачлалтай хамаарлтай хариуцах хүмүүс болон бусад холбогдох талуудтай цахим шуудан, утсаар болон/эсвэл видео хурлаар ярилцлага, зөвлөлдөх зэрэг орно. Ярилцлага,</p>	<p>Тайлан: Уул уурхайн салбарын нийгэм-эдийн засгийн нөлөөллийг үнэлэх, үнэлэх үзүүлэлтүүдийг хөгжүүлэх болон/эсвэл ашиглах Монгол Улсад байгаа чадавхи ба мэдээлэл'</p> <p>Энэхүү тайланд дараах зүйлийг багтаасан байх ёстой.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол улсад хэрэгжиж буй тогтолцооны шинжилгээнд ашигласан аргачлалын тодорхойлолт.</li> <li>• Шалгасан системүүдийн иж бүрэн дүн шинжилгээ (30-40 хуудас), үүнд:             <ul style="list-style-type: none"> <li>• уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг хянах шалгуур үзүүлэлтийг боловсруулахад ашиглах мэдээлэл;</li> <li>• уул уурхайн салбарын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг хянахад хувь нэмэр оруулах боломжтой үзүүлэлтүүд;</li> <li>• энэ мэдээлэл, үзүүлэлтүүдийн хүртээмжтэй байдал;</li> <li>• Тэдгээрийг бий болгож буй агентлагуудтай хамтын ажиллагааг бий болгох боломж, сорилтууд;</li> <li>• тодорхойлсон мэдээллийн цоорхой; болон</li> <li>• Ашигтай гэж тодорхойлсон мэдээлэл, үзүүлэлтүүдийг ашиглах бусад анхаарах зүйлс.</li> </ul> </li> </ul>

	<p>зөвлөгөөнийг УУХҮЯ, БГР төсөлтэй урьдчилан тохиролцоно.</p> <p><b>4.</b> Ажлын хэсэгт танилцуулж, үр дүнг хэлэлцэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>Бүрэн дүрсэлсэн хуудас (тайлангийн хавсралт болгон оруулсан болно).</li> </ul> <p>- AX-т танилцуулах үр дүнгийн талаарх илтгэл</p> <p>- AX болон оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлгийн баримтжуулалт</p>
4	<p>5. Геологи, үул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг үнэлэх ба дүгнэх ажлыг чиглүүлэх аргачлалын бүрэн ажлын багцын санал боловсруулах</p> <p>6. Ажлын хэсэгт танилцуулж, үр дүнг хэлэлцэх</p>	<p>Тайлан: Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг үнэлэх ба дүгнэх ажлыг чиглүүлэх аргачлалын бүрэн ажлын багцын санал</p> <p>- AX-т танилцуулах үр дүнгийн талаарх илтгэл</p> <p>- AX болон оролцогч талуудтай хийсэн хэлэлцүүлгийн баримтжуулалт</p>

Бүх баримт бичгийг англи, монгол хэл дээр бичиж дижитал хэлбэрээр (word, pdf, ppt) өгнө.

#### 4.5 Төсөл боловсруулах урьдчилсан хугацааны хуваарь

	Cap 1	Cap 2	Cap 3	Cap 4	Cap 5	Cap 6	Cap 7	Cap 8	Cap 9
Ажлын нарийвчилсан төлөвлөгөө									
Салбарын нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, үнэлгээний аргачлалын олон улсын туршлага'									
Уул уурхайн салбарын нийгэм-эдийн засгийн нөлөөллийг үнэлэх, үнэлэх үзүүлэлтүүдийг хөгжүүлэх болон/эсвэл ашиглах Монгол Улсад байгаа чадавхи ба мэдээлэл'									
Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг үнэлэх ба дүгнэх ажлыг чиглүүлэх аргачлалын бүрэн ажлын багцын санал									
Санал хүсэлтийг шийдвэрлэх, эцсийн тайланг нэгтгэх, даалгаврыг хаах.									

Даалгаврыг 2024 оны 8 сараас эхлэн 8 сарын хугацаанд гүйцэтгэн 2025 оны 3 сард дуусгахаар төлөвлөж байна.

#### 4.6 Зөвлөх багт тавигдах шаардлага

##### Зөвлөх компанид:

Зөвлөх компани нь нийгэм-эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ эсвэл төрийн бодлогод хяналт тавих шалгуур үзүүлэлтийн системтэй холбоотой дор хаяж хоёр төсөл, судалгааг гүйцэтгэсэн нотлох баримтыг бүрдүүлэх ёстай.

##### Зөвлөх багт:

Зөвлөх компани нь дор хаяж гурван хүнээс бүрдсэн зөвлөх багийг санал болгох ёстай.

### Багийн ахлагч

- эдийн засагч, социологич, бизнесийн удирдлага эсвэл инженерийн мастераас дээж зэрэгтэй.
- Уул уурхай, геологи, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх төрийн бодлого болон/эсвэл үнэлгээний тогтолцоог боловсруулах, дүн шинжилгээ хийх чиглэлээр төрийн болон хувийн хэвшилд судалгаа, зөвлөгөө өгөх чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.
- Одоогийнхтой ижил хэмжээний, хамааралтай 2 төсөл боловсруулж, дор хаяж нэг төсөлд тухайн хүн тухайн төслийн ерөнхий зохицуулагчаар ажиллаж байсан туршлагатай.
- Монгол ба Англи хэлний бичгийн чадвар маш сайн байх.

### Геологи, уул уурхайн чиглэлийн мэргэжилтэн

- Геологи, уул уурхай, газарзүйн физик, хими, химийн инженерчлэл эсвэл холбогдох сэдвээр бакалаврын түвшинд эрдмийн зэрэгтэй байх.
- Уул уурхай, геологи, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах чиглэлээр дор хаяж 4 жил ажилласан, шинжлэх ухааны судалгаа эсвэл түүнтэй адилтгах эсвэл харьцуулах боломжтой сэдвээр туршлагатай.
- Дор хаяж 2 ижил төстэй төсөлд оролцож байсан туршлаганаа харуулсан.
- Монгол ба Англи хэлний бичгийн чадвар маш сайн байх.

### Судалгааны мэргэжилтэн

- Эдийн засаг, төрийн удирдлага, математик эсвэл холбогдох сэдвээр бакалаврын түвшинд хамгийн бага эрдмийн зэрэгтэй байх.
- Уул уурхай, геологи, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах чиглэлээр дор хаяж 4 жил ажилласан, шинжлэх ухааны судалгаа эсвэл түүнтэй адилтгах эсвэл харьцуулах боломжтой сэдвээр туршлагатай.
- Хамгийн багадаа 2 судалгаанд тэргүүлэх зохиогч, судлаачаар ажилласан туршлагатай байх.
- Монгол ба Англи хэлний бичгийн чадвар маш сайн байх.

### 4.7 Саналыг үнэлэх, шалгаруулах

Сонгох шалгуур: хуримтлагдсан дүнгийн оноогоор. Техникийн ба санхүүгийн хамгийн сайн хослолыг хангасан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулна. Нийт онооны 50%-ийг техникийн санал, 50%-ийг санхүүгийн санал эзлэнэ.

Дараахь шагналын шалгуурын дагуу:

№	Ерөнхий шалгуур	Оноо эзлэх хувь (%)	Баталгаажих
1	Үнэ	50	Санхүүгийн санал
2	Гүйцэтгэл	50	Техникийн санал

Гүйцэтгэлтэй холбоотой дараах үнэлгээний шалгуурыг тогтоосон болно.

№.	Шалгуур	Оноо	Эзлэх хувь (%)	Үнэлгээнд шаардлагатай нотлох баримт
1	Ирүүлсэн санал нь тодорхой, онолын болон практикийн хувьд үндэслэлтэй, даалгаврын хамрах хүрээ, зорилгын талаар бүрэн ойлголтыг тусгасан, зөвлөх багийн туршлагад үндэслэн тулгарч буй бэрхшээл, тэдгээрийг цаг тухайд нь зөв шийдвэрлэх боломжийг тодорхойлсон	0-3	50	Техникийн санал

	байна. Мөн энэ нь хүссэн үр дүнг сайжруулах эсвэл нэмэлт хувь нэмэр оруулах саналууд багтсан байна.			
2	Монгол улсын эрдэс баялгийн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх НЭЗҮ аргачлалын тогтолцоог бүрдүүлэх зааварчилгааны хамт даалгаврын тодорхойлолтын зорилгын дагуу цуглуулсан мэдээллийг зорилтот түвшинд үнэлэх арга зүй	0-3	50	Техникийн санал

#### Үнэлгээний шалгуурыг 0-ээс 3 хүртэлх оноогоор үнэлнэ:

- 3 оноо: Бүх зүйл дээр үйлчлүүлэгчийн хүлээлтийг бүрэн хангасан сайн санал эсвэл ажлын даалгаварт заасан ажлуудад гүйцэт хариу өгсөн бол.
- 2 оноо: Хангалттай, дундаж танилцуулга эсвэл даалгаврын хариуг өгсөн, үндсэн зүйлүүдэд үйлчлүүлэгчийн тавьсан шаардлагыг хангасан.
- 1 оноо: Тохиромжгүй танилцуулга, эсвэл үүрэг даалгаварын шаардлагын чухал талуудыг хангалтгүй тусгасан.
- 0 оноо: Тохиромжтой бус, ойлгомжгүй танилцуулга эсвэл ажлын албаны шаардлагын хариу.

Тендерт оролцогчийн ажлын даалгаварт тусгагдсан шаардлага, зорилгын талаархи саналд үзүүлсэн биелэлт, амжилтын зэрэгт үндэслэн оноог олгоно.

#### 4.8 Санхүүгийн хувьд хамгийн ашигтай саналыг тодорхойлох

Техникийн саналыг үнэлсний дараа саналуудын гүйцэтгэл, үнийн харьцааны утгыг харьцуулан эдийн засгийн хувьд хамгийн ашигтай саналыг тодорхойлно.

$$Z = \frac{L}{P}$$

параметрүүдийг дараах байдлаар тодорхойлно.

Z: Үнийн гүйцэтгэлийн харьцааны үзүүлэлт

L: Гүйцэтгэлийн нийт оноо (үнэлгээний оноо \* жинлэх)

P: Санхүүгийн саналын дагуу үнийг санал болгоно.

Хамгийн их Z утгатай саналд гэрээ байгуулна. Хэрэв өөр өөр саналуудын гүйцэтгэл-үнийн харьцаа (Z)-ийн үүссэн үзүүлэлт нь яг ижил байвал хамгийн хэмнэлттэй санал ирүүлсэн этгээдтэй гэрээ байгуулахаар шалгаруулна.

#### 4.9 Зохиогчийн эрх ба нүүцлэл

Судалгааны үр дүн, судалгааны гүйцэтгэлтэй холбогдуулан олж авсан мэдээлэл, тэдгээрийн тайлбар нь захиалагчийн өмч болно. Гүйцэтгэгч нь захиалгыг биелүүлсний дараа завсрын үр дүн болон бичгээр баримт бичгийг захиалагчид хүлээлгэн өгөх бөгөөд энэ мэдээллийг гуравдагч этгээдэд амаар болон бичгээр дамжуулахгүй.